



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

### Ногдол ашиг төвлөрүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 76 дугаар зүйлийн 76.1.12, Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 88 дугаар тогтоолын 1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 388 дугаар тогтоолын 2.1 ба 2.2 дахь заалтууд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 307 дугаар тогтоол, Сангийн сайдын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 99 дугаар тушаалын 3 дахь заалт, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.14 дэх заалтууд, Аудитын хорооны дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 307 дугаар тогтоолоор баталсан, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн 2021 оны цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн төлбөрөөс 500,000,000 /Таван зуун сая/ төгрөгийг Улсын төсөвт төлж, төвлөрүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан дээрх 2021 оны цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн үлдэгдэл төлбөрийг үе шаттайгаар төлж, төвлөрүүлэх талаар Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт санал, хүсэлт хүргүүлж, зохих чиглэл, шийдвэрийг тухай бүрт компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.
3. Ногдол ашгийн төвлөрүүлэлтийн талаар холбогдох хууль, дүрэм, журмын дагуу компанийн Хувьцаа эзэмшигчид болон зохих байгууллагуудад мэдэгдэл хүргүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /А.Анар/-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.СҮХ-ОЧИР

1522010048